


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд **30334,7 сая** төгрөгийн орлого бүрдүүлсэн ба шимтгэлийн орлогын төлөвлөгөөг **93,13** хувиар биелүүлсэн.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 101-107,5 хувиар 1-8 саруудад жигд ханган биелүүлэн ажилласан ба 9 дүгээр сараас эхлэн Бор-Өндөр Монросцветмет Уулын баяжуулах нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөө төлөхгүй өр үүсгэснээс орлогын төлөвлөгөө тасарсан болно.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж байгууллага, иргэнийг хамруулах, хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд ажил олгогч **935**, заавал даатгуулагч **14204** болж, оны эхнээс шинээр **58** ажил олгогч, **348** даатгуулагчийг бүртгэн, шимтгэл тооцох цалингийн сан **1070,1** сая төгрөгөөр нэмэгдлээ.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлого сан тус бүрээр




Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрэлдэхүүн




НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төлөвлөгөө **80916,1** сая төгрөгөөс **80263,5** сая төгрөгийн зарлагыг батлагдсан төсөвт багтаан хэтрүүлэлгүй ажилласан. Нийт зардлын **90,4** хувийг тэтгэврийн даатгалын сан эзэлж байна. 2022 онд давхардсан тоогоор **160** гаруй мянган

даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд нь тогтоон бүрэн олгож, тэтгэвэр авагч, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг жигд, хүртээмжтэй, чирэгдэлгүй хүргэлээ.



Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн зарлага сан тус бүрээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад



Зураг 2. Нийгмийн даатгалын үйлчилгээ авагчдын тоо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАГДАЛТ

Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалын мэдээллийн санд 2022 оны байдлаар нийт **935** төсвийн болон аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэн нь эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагын **85** хувийг эзэлж байна. Мөн албан журмын болон сайн дурын даатгалд 18,1 мянган даатгуулагч хамрагдсан нь эдийн засгийн идэвхтэй хүн амын **48,5** хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд шинээр **58** ажил олгогч хамруулсан ба албан журмын **348** даатгуулагчийг нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэн нийгмийн даатгалын шимтгэлийн

тайлан тооцоог хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулан ажиллаа.

Аймгийн хэмжээнд нийт **3886** даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдсанаас шинээр **1525** даатгуулагч хамрагдсан. Үүнээс: малчин **1040** даатгуулагч шинээр хамрагдсан байна. Мөн 0-3 нас хүртэл хүүхдээ асарч байгаа **720** эх даатгуулагч нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамрагдан шимтгэл төлж байна. Хагас жилийн байдлаар 0-3 насны хүүхдээ асарч байгаа **279** даатгуулагч эх шинээр хамрагдсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН АВЛАГА

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах, тайлант хугацаанд шинээр үүссэн авлагыг барагдуулах чиглэлээр ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллаж олон ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

- Оны эхний 169 ажил олгогчийн хуримтлагдсан авлага 584,4 сая төгрөгийн авлагаас 121 байгууллагын 393,0 сая төгрөг буюу **67,2%**-г барагдуулсан байна.
- Шүүхийн шийдвэртэй 4 байгууллагын 20,9 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй авлагатай. Тус авлагаас 0,3 сая төгрөгийн авлага барагдсан болно.
- Борондрийн Монросцветмет уулын баяжуулах үйлдвэр 9-р сараас эхлэн улс орны хямрал цаг үеийн байдал, хил гаалиас болж шимтгэлийн авлагыг сардаа 900,0

сая төгрөгөөр үүсгэн оны эцэст 3600,0 сая төгрөг буюу нийт авлагын 80,9 хувийг дангаараа эзэлж байна.

- Оны эцэст нийт 4450,0 сая шимтгэлийн авлагатай гарч байгаа бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээ 15,1 хувийг эзэлж байна.
- Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхэнд байхгүй бөгөөд тайлант хугацаанд шимтгэлийн авлага үүсгэлгүй ажилласан. 2021 оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлттэй холбоотой үүссэн 48,9 сая төгрөгийн илүү төлөлт буюу өглөгийг эхний хагас жилд ногдуулалтыг хийж барагдуулж ажилласан.

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа **12311** тэтгэвэр авагчид **73,2** тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу шинээр **926** иргэн тэтгэвэр тогтоолгосноос өндөр насны тэтгэвэр 679, тахир дутуугийн тэтгэвэр 188, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 42, цэргийн тэтгэвэр 17 байна. Тэтгэврийг хамтран ажиллах гэрээний дагуу арилжааны банкуудаар сар бүрийн 01-нд олгож хэвшсэн.

Хүснэгт. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэврийн төрөл	Суурь түвшин буюу 2021 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2022 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Өндөр насны	9552	43568,8	10000	60678,8
Тахир дутуугийн	1408	6108,5	1490	7073,2
Тэжээгчээ алдсаны	588	2610,5	569	3055,2
Цэргийн	210	2055,8	252	2389,2
НИЙТ	11758	54343,6	12311	73196,4

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



Тэтгэмжийн даатгалын сангаас **4570** даатгуулагчдад **2,9** тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олгов. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад **55,5** сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт . Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Тэтгэмжийн төрөл	Суурь түвшин буюу 2021 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2022 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан оны хагас жил хөрөнгө
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	2996	505,5	3270	934,2
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	1201	1912,4	983	1637,2
Оршуулгын тэтгэмж	360	415,0	317	317,0
НИЙТ	4557	2832,9	4570	2888,4



3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө төлсөн тохиолдолд үлдсэн 50 хувийг даатгуулсан эсэхээс хамаарч тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс олгохоор шийдвэрлэсэн хуулийн хүрээнд 720 эхчүүдтэй гэрээ байгуулж тэтгэмжийн даатгалын сангаас **70,6** сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн орлогод төвлөрүүлэн ажиллаа.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



ҮОМШӨ-ний даатгалын сангаас **529** тэтгэвэр, тэтгэмж авагчдад нийт **3170,4** сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ онд шинээр 34 даатгуулагч тэтгэвэр тогтоолгосонба өмнөх оны мөн үетэй харьцуулахад зардал 412,3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт. Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2021 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2022 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
ҮОМШӨ-ний тэтгэвэр	387	2480,6	393	2934,2
ҮОМШӨ-ний тэтгэмж, төлбөр	48	60,7	125	59,7
Тахир дутуу иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэл	378	216,8	340	176,5
НИЙТ	813	2758,1	858	3170,4

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Ажилгүйдлийн даатгалын сангаас **482** даатгуулагчид ажлаас халагдсаны тэтгэмжид **1008,3** сая төгрөг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 221,3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Суурь түвшин буюу 2021 оны мөн үе		Хүрсэн түвшин буюу 2022 он	
	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө
Ажилгүйдлийн тэтгэмж	384	787,0	482	1008,3
Сургалтын төлбөр	0	0	0	0

ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХҮНИЙ НӨӨЦ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тус хэлтэс нь 2022 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар 4 тасаг 47 орон тоотой батлагдсан бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар орон тооны гүйцэтгэл 41 байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангах зорилт тавин ажиллаа.

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019.01.01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан төрийн албаны шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн иргэн байхгүйн улмаас өндөр насны тэтгэвэр, жирэмсэн, амаржсан, хүүхдээ асрах чөлөө авсан ажилтны сул орон тоог (ялангуяа

сумдад) нөхөхөд хүндрэл үүсэж, төрийн албаны тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулж байна. Өнөөдрийн байдлаар Дэлгэрхаан, Баянхутаг сумын, Өлзийт тосгоны байцаагч мөн Бичиг хэрэг, хүний нөөцийн мэргэжилтэн, Сургалт сурталчилгаа, мэдээлэл технологийн мэргэжилтэн, шимтгэлийн байцаагч гэсэн албан тушаалын сул орон тоо гарч зохих хууль, тогтоомжийн дагуу аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн боловч нөөцөд шаардлага хангасан ажилтан байхгүй байна.

№	Албан тушаалын ангилал	төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Удирдах албан тушаалтан	1	1
2	Гүйцэтгэх албан тушаалтан	41	35
3	Үйлчилгээний	5	5
Нийт		47	41

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 2022 онд **848,3** сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн 576,4 сая төгрөгийг цалин хөлсөнд, нийгмийн даатгалын шимтгэлд 72,1 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 27,7 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 20,7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 3,5 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 2,3 сая төгрөг, томилолтын зардалд 2,8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,9 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 5,7 сая төгрөг, мэдээлэл сурталчилгаанд 3,0 сая төгрөг, өмгөөлөл хуулийн зөвлөх үйлчилгээний зардалд 0,4 сая төгрөг, ЭХМК-н зардалд 15,7 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулалд 116,0 сая төгрөгийг тус тус эдийн засгийн ангилал зориулалтаар нь батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан.

➤ Хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон

төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Аймгийн Аудитын газар **ЗӨРЧИЛГҮЙ** дүгнэлт өгсөн.

“Нийгмийн даатгалын байгууллагын угтах үйлчилгээний журам” болон ирүүлсэн чиглэлийг тус тус хэрэгжүүлэн угтах үйлчилгээний ажилтан орон тоогоор ажиллуулж байна. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2011 оны 72 тоот тушаалын дагуу 2016 оноос Зүүн бүсийн Эвт худалдааны төвд байрлах **ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД** эрүүл мэндийн даатгалын орлого, сайн дурын даатгал хариуцсан байцаагч тогтмол ажиллаж байна.



ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх

тухай.

Засгийн Газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд баримтлах НДЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн А/17 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг баримтлан ажиллаа.

Батлагдсан зааврын дагуу Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн




даатгалын сангаас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа 12230 тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэн 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож тэтгэврийн доод хэмжээнээс дээгүүр тэтгэврийн тогтоолтын хуудсанд гараар баяжилт хийж, доод хэмжээний тэтгэврийн тогтоолтын хуудсыг хэвлэн баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргасан.



3. Албан хаагчдын дунд монгол бичгийн түвшин тогтоох шалгалт авч Хэрлэн 4 дүгээр сургуулийн Монгол хэл бичгийн багш Э.Эрдэнэсүвдтай гэрээ байгуулан 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай долоо хоног бүрийн 3 дахь өдөр болгон 1 цагийн хичээл заалгасан. Хичээлд 18 албан хаагч хамрагдаж байна.

МОНГОЛ ХЭЛ. ҮНДСЭНИЙ БИЧГИЙН ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ				
АНХАН ДУНД ШАТНЫ СУРГАЛТЫН АГУУЛГА				
№	Хичээлийн сэдэв	Цэг	Хичээлэх өдөр	Хүрэх үр дүн
1	Үндэсний бичгийн үндсэн гурвалыг ажиг танил, эгшгэг үсгийг танил ажигнуулыг бичих дадлага авах	1 шг		
2	БА, ХА, ДАРА, Я нийгүүлчийг танил, ажигнуулыг бичих дадлага авах	1 шг		Үсэг үеэ сүргэн санаж, үндэсний бичгээр бие даан унших бичих чадартай болно.
3	НГ-ийг танил: БА, ГА, ХА, ДА, ТА үсгийн танил, эгшгэг ажигнуулыг бичих, унших	1 шг		
4	СА, ША, ХА, ЖА, ЦА, ЧА үсгийн бичиглэл ажигнуулыг бичих	1 шг		
5	Галтгаал: үндэсний бичгээр танил бичиглэл	1 шг		
6	Байрм бичгээр танил шатны ажиглалтыг бичих дадлага авах	1 шг		
7	Эгшгэг үсэг бичих дадлага	1 шг		
8	Танил бичих дадлага	1 шг		
9	Танил үсэг бичих дадлага	1 шг		
10	Үе бичих дадлага	1 шг		
11	Үг бичих дадлага	1 шг		
12	Танил байрм бичих дадлага	1 шг		
13	Танил байрм бичих дадлага	1 шг		
14	Бүтээл бичих дадлага	1 шг		
15	Бүтээл бичих дадлага	1 шг		
16	Тайланг өгөрөөх	1 шг		



Мөн 11 дүгээр сарын 01-нээс Насан туршийн боловсролын төвтэй гэрээ байгуулан багш Л.Чинбатаар дунд шатны хичээлийг 7 хоног бүрийн 5 дахь өдрийн 16 цагаас нэг цагийн хичээл орж байна.



4. НДЕГазраас зохион байгуулж байгаа цахим Монгол бичгийн хичээлд 8 албан хаагч хамрагдан суралцсан.

5. “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага”, “Монгол бичгийн цахим бичвэр боловсруулах

анхан шатны мэдлэг олгох, Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй” сэдэвт сургалтуудад бичиг хэрэг, архивын ажилтанг хамруулсан.

“ Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль”-ийн хэрэгжилт



Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийн буцаан олгох тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг З-НД7,8 тайланг хуулийн хугацаанд тоон гарын үсгээр хүлээн авч баталгаажуулсан. Тус хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шинээр нэвтэрсэн 2 төрлийн программыг үйл ажиллагаандаа ашиглан Хэнтий аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 42544 даатгуулагчидад 139.1 сая төгрөгийн буцаан олголтыг олгосон байна. Мөн нэр данс зөрүүтэй 812 даатгуулагчийн мэдээллийг арилжааны банкуудтай хамтран ажиллаж мэдээллийг зөв болгон мэдээллийн санд хадгалсан. Ажил олгогчийн даатгуулагчтай холбоотой 8 алдаанаас засагдах боломжтой 6 алдааг зассан. Тооцооны алдааны улмаас 12 ажил олгогчийн нэр бүхий 13 даатгуулагчид олгосон 512,2 мянган төгрөгийн илүү төлөлтийг нийгмийн даатгалын сангийн ерөнхий орлогын дансанд төлүүлсэн.

“Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан”-г сайн дурын даатгалд хамруулах



Хөдөлмөрийн хууль / шинэчилсэн найруулга/-ийн 71.8 дахь хэсэгт “Туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, тэдгээртэй адилтгах ажилтан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1,2,4 дэх заалтад заасан даатгалд сайн

дураар даатгуулна”, гэсний дагуу сумын байцаагчид ажил олгогч, иргэд даатгуулагчид мэдээлэл хүргэж ажилласнаар **30** туслах малчин, **3** гэрийн үйлчилгээний ажилтныг хамруулсан.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд заасан эрх үүргийн хүрээнд хяналт шалгалт хийх, аливаа хууль бус үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүргийн хүрээнд ажиллаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хяналт шалгалт дотоод аудитын тасгийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 10 суманд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх хуваарийн дагуу ажил олгогч даатгуулагчдын цалингийн сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлж байгаа эсэх, нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд Батширээт суманд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Тус шалгалтаар 2 байгууллагатай холбоотой 8.5 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж 3,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулсан байна. Ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу гадагшаа чиглэсэн хяналт шалгалтын ажлыг түр зогсоож Дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх үүрэг чиглэл өгсний дагуу Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилт, тэтгэмжийн даатгалын сангийн тогтоолт олголт, Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох малчны зөвлөлийн тогтоолыг тус тус холбогдох хууль тогтоомж дүрэм журамд нийцүүлэн дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаа.

Архив албан хэрэг хөтлөлтөд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр баримт бичиг нягтлан шалгах комиссыг хэлтсийн даргын тушаалаар шинэчлэн байгуулсан. Мөн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг төрийн архиваар батлуулан жагсаалтын дагуу ажилтнуудаас тухайн оны санхүүгийн болон бусад баримтыг хүлээн авах хуваарийг хэлтсийн даргын тушаалаар баталж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаа. Сумдын байцаагчдаас Байнга хадгалах буюу нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 3-НД7,8 тайлангийн хадгаламжийн нэгжийг нэг бүрчлэн мэдээллийн сантай үлдэгдлийг тулган, тамга, тэмдэг дарагдаж баталгаажсан эсэхэд хяналт тавьж хэлтсийн архивд хүлээлгэн өгсөн. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан холбогдох эрх зүйн актуудтай тухай бүр танилцан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны тус хэлтсийн дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл 52.8 сая байсан ба тайлант хугацаанд шинээр 45.05 сая төгрөгийн зөрчил илрэн улсын байцаагчийн актаар баталгаажуулсан. Үүнээс 60.8 саяыг барагдуулан ажилласан бөгөөд оны эцсийн байдлаар 37.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авагч даатгуулагчийн материалын үндэслэл олголтыг тус тус шалгаж 6 даатгуулагчтай холбоотой 5.3 сая төгрөгийн

зөрчил илрүүлж 3.5 сая төгрөгийг барагдуулаад байна. Хагас жилийн тайлангаар 1 албан хаагчтай холбоотой 11.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнийг барагдуулан ажилласан. Мөн 8 тэтгэвэр авагчтай холбоотой 27.4 сая төгрөг илүү олгосон байсныг улсын байцаагчийн актаар баталгаажуулан 23.8 саяыг барагдуулсан байна.

НДЕГ-аас ирүүлсэн удирдамжийн дагуу тэтгэмжийн даатгалын санд шалгалт хийсэн. Шалгалтаар 20 даатгуулагчтай холбоотой 19,9 сая төгрөгийн зөрчил илэрснээс Эмнэлгийн хуудсанд бичигдсэн овог нэр, регистрийн дугаар засвартай, гарын үсэг, тамга тэмдэг дутуу 11 даатгуулагчийн баримтыг нөхөн бүрдүүлж зөрчилийг арилгасан, 2 даатгууланчийн 0,8 сая төгрөгийн дутуу олгосон тэтгэмжийг олгож, сайн дурын даатгалыг нөхөн төлсөн боловч алданги тооцоогүй үүнээс болоод сүүлийн 6 сар тасарсан, тэтгэмж бодсоноос хойш цалинг устгасан, ажил олгогчийн цалин сайн дураар төлсөн шимтгэл давхардсан, сайн дураар даатгуулсан даатгуулагчийн цалин давхар татагдаж бодогдсон зэрэг 6 даатгуулагчтай холбоотой 3.6 сая төгрөгийн тэтгэмж илүү олгосон зөрчлийг бүрэн барагдуулсан.

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчээр ажилснаар тооцуулан нөхөн төлүүлсэн хугацааг сар бүрээр тулган шалгаж давхардуулан тооцсон сарыг залруулах, малчны А данстай өөр онуудын сард шилжүүлэх, шилжүүлэх боломжгүй тохиолдолд буцаан олгох шалгалтыг хийсэн. Шалгалтаар 122 даатгуулагчийн материалыг дахин шалгасны 71 даатгуулагч тэтгэвэр тогтоолгон тэтгэврээ хэвийн авч байгаа бөгөөд давхар тооцсон сарууд одоо авч байгаа тэтгэвэрт нөлөөлөхөөргүй байна. Үлдсэн 51 даатгуулагчийн давхардсан сарыг бусад оны А данстай сарлуу шилжүүлэх материалыг дахин бүрдүүлэхээр сумдын байцаагч нарт чиглэл өгсөн. Нийгмийн даатгалын хэлтэстэй гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллага болон эмийн сангуудын эм зүйч, жор баригч нарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг удирдамжийн дагуу шалгаж тайланг хугацаанд нь хүргүүлсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн бүрэн бүтэн байдал хадгалалт хамгаалалтыг тэтгэврийн массив болон нэгдсэн мэдээллийн баазтай тулган шалгахад 22 сумын байвал зохих **13314** хувийн хэрэг бүрэн тоологдсон. Тооллогын явцад тэтгэвэр авагчдын хувийн хэргийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, нэгдсэн мэдээллийн сангийн массивын дарааллын дагуу эмхэлж цэгцэлж хадгалалт хамгаалалтыг сайжруулан хавтас хаягийг сайжруулах үүрэг өгч ажилласан.

ЦАХИМ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

“Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг хийж программаар шүүгдсэн алдааг шалган тухай бүр залруулга хийж байна. Нийгмийн даатгалын сангуудтай холбоотой цахим хяналтын программаар шүүгдсэн алдааг тухай бүр шалгаж мэдээллийг оруулж

байна. Тус программын шүүлтээр гарсан алдаа дутагдлыг нэн даруй залруулах боломжтойг нь Санхүү бүртгэлийн тасагтай хамтран санхүүгийн анхан шатны баримтыг үндэслэн шалгасны үндсэн дээр 2022 оны эцсийн байдлаар 37 ажил олгогчийн 99 даатгуулагчтай холбоотой засварыг хийсэн байна. Ажил олгогчийн цалин өөрчилсөн 225 алдаа шүүгдсэнээс 86 алдааг шалгаж тэмдэглэл оруулсан. Тэтгэвэр тогтоосон цалингийн мэдээлэл цэснээс 2022 онд 12 даатгуулагчийн тэтгэвэр тогтоосон цалин, нэгдсэн мэдээллийн сангийн цалин хоёр зөрүүтэй байсныг шалган шийдвэрлэж, шаардлагатай зарим тэтгэвэр авагчийн хувийн хэргийг сумдаас татан авч шалган тэмдэглэл хийсэн. Тус цахим хяналтын программын шүүлтээр гарсан алдааны жагсаалтыг сар бүр хөрвүүлж анхан шатны нэгжид хүргүүлэн залруулах чиглэл өгч, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

ЗӨРЧИЛЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР

Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтны судалгаа тайлан мэдээ болон Зөрчлийн гомдол мэдээлэлтэй холбоотой судалгааг гарган цаг хугацаанд нь хийж Хэнтий аймгийн прокурорын газарт болон НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газарт тус тус хүргүүлсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 9 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой гомдол мэдээллийг хүлээн авсанаас 7 байгууллагын материалыг хянан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шийдвэрлэж буруутай 2 албан тушаалтныг 200 нэгжээр, 6 байгууллагыг 250 нэгжээр тус тус торгон нийт 1.9 сая төгрөгийн торгууль ногдуулсаныг барагдуулан ажилласан. 1 төсөвт байгууллагатай холбоотой гомдол мэдээлэлд Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэх үндэслэлээр гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр гаргаж прокурорт хянуулж цахимд бүртгүүлсэн. Мөн 1 аж ахуй нэгж байгууллагатай холбоотой гомдол мэдээллийг хянан зөрчлийн хэрэг үүсгэн шийдвэрлэсэн. Дээрхи 8 байгууллагатай холбоотой гомдол мэдээллийн дагуу Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 11.9 төгрөгийн акт, алданги ногдуулсаныг бүрэн барагдуулсан. Зөрчлийн тухай хуулинд орсон өөрчлөлт, хяналт шалгалтаар илэрч буй нийтлэг алдаа зөрчлийн талаар албан тоотыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн.

ДОТООДЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Хяналт, шалгалтын тайланг улирал бүр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулж, НДЕГ-ын ХШГазарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Дотоодын хяналт, шалгалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт дотоод аудитын тасаг нь 2022 онд хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж мөн хэлтсийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 1/21 тоот, 10 дугаар сарын 23-ний өдрийн 1/313 тоот албан бичгээр актын үлдэгдэлтэй, бусад авлага барагдуулж нийгмийн даатгалын санг хохиролгүй болгох ажлыг шуурхай зохион байгуулах хугацаатай үүрэг чиглэл өгч ажиллаа. Тайлант хугацаанд төлбөр

зөрчлийн эхний үлдэгдэл 52.8 сая, шинээр үүссэн 45.05 сая төгрөгөөс 60.8 сая төгрөг буюу нийт ногдуулсан төлбөр зөрчлийн **62,1** хувийг барагдуулсан байна.

АЖТДШНТТ хуулийн дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл, хөдөлмөрийн дэвтрийн хуулбар, бусад баримтуудыг архивын зааврын дагуу архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэн хадгалж байгаа баримтнаас тэтгэвэр тогтоолгохоор ирүүлсэн 28 малчин өндөр насны тэтгэврийн хувийн хэрэг материалыг архивын баримттай тулган шалгасан бөгөөд зөрчил илрээгүй байна.

Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тэтгэврийн даатгалын сангийн 2020, 2021 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, мөн тухайн онуудад шинээр тогтоогдсон тэтгэврийн тогтоолт олголтын байдалд 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 07 дугаар сарын 01-ний өдрийн хооронд шалгалт хийгдсэн. Шалгалтаар 44 тэтгэвэр авагчдад дутуу олгогдсон 8.1 сая, 4 тэтгэвэр авагчид илүү олгосон 333.8 мянган төгрөг, 2 даатгуулагчид сайн дурын даатгалын шимтгэл 291.3 мянган төгрөг илүү олгосон зөрчил илэрсэн. Гарсан төлбөр зөрчилтэй холбоотой хугацаатай албан шаардлагын дагуу илэрсэн зөрчлийг 08 дугаар 01-ний өдрийн дотор залруулан мэдээг мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн.

НДЕГазрын ХШГазрын 2021 оны тэтгэврийн даатгалын санд хийгдсэн төлөвлөгөөт шалгалтаар тус хэлтсийн 1079 тэтгэвэр хамрагдсан бөгөөд хуурамч материал бүрдүүлж тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 11 даатгуулагчтай холбоотой 64,2 сая төгрөгийн төлбөр зөрчилд Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа хийж, улсын байцаагчийн акт тогтоосон. Хуурамч материал бүрдүүлэн тэтгэвэр тогтоолгосон Батноров сумын иргэн Ц.Занданпүрэв, Биндэр сумын иргэн Д.Хурцбаатар нарын тэтгэврийг зогсоон үндэслэлгүй авсан 4.6 сая төгрөгт улсын байцаагчийн акт тогтоосон байсныг Хэнтий аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр баталгаажуулан 1.7 сая төгрөгийг барагдуулсан. Д.Хурцбаатарт холбогдох 2.9 сая төгрөгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

Нас барсан тэтгэвэр авагчдын олголтыг хянахад НДСОТТТХуулийн 6 дугаар зүйлийг зөрчиж 15 хүнд дараа сарын тэтгэвэр болох 30.1 сая төгрөгийг илүү олгосныг 26.5 сая төгрөгийг тэтгэврийн харилцах дансанд татан авч төлүүлэн зөрчлийг барагдуулан ажилласан. Сайн дурын даатгал төлөгч 35 даатгуулагчтай холбоотой мэдээллийн баазад засвар хийх гомдол мэдээллийг хүлээн авч залруулгын акт бичин хуулийн хугацаанд шийдвэрлээд байна. Мөн албан журмын даатгуулагчийн цалин, төрөл, үндсэн мэдээлэл залруулах хүсэлтийн дагуу 37 байгууллагын материалыг хянан шийдвэрлэсэн.

Үнэт цаас эзэмших эрхтэй нас барсан тэтгэвэр авагчдын үнэт цаасыг гэр бүлийн гишүүнд нь өвлүүлэх, нас барсан иргэдийн үнэт цаасыг мөнгөжүүлэхтэй холбогдох баримт бичгийг бүрдүүлж Нийгмийн даатгалын ерөнхийн газрын Дотоод аудит мониторингын газарт хүргүүлж байна. Нийт нас барсан иргэдийн тоо- 193 үүнээс өв залгамжлал олгосон иргэдийн тоо-178, өв залгамжлал олгогдоогүй 15 иргэн байна. Олгогдоогүй үнэт цаасыг мөнгөжүүлэх ажлыг сумдын байцаагч нартай хамтран зохион байгуулж ажиллаж байна.

Оны эхний улсын байцаагчийн актаар тавигдсан 50,6 сая төгрөгийн үлдэгдлээс 10,5 сая буюу 20,7 хувийг барагдуулаад байна. Дээд шатны байгууллагаас ирүүлсэн 1 даатгуулагчтай холбоотой 2019 оны тэтгэврийн даатгалын сангийн 3.5 сая төгрөгийн авлагаас 2.5 сая төлөгдөж 1,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ГОМДЛЫН ШААРДЛАГЫН ЗӨВЛӨЛ

2022 онд Гомдлын шаардлагын зөвлөлд 3 өргөдөл гомдол ирснээс Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, “Ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм” – ийг тус тус баримтлан 3 удаа хуралдаж 2 даатгуулагчийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэн тогтоол гаргасан байна. 1 даатгуулагчийн материал дутуу нотлох баримт хангалтгүй гэж үзэн буцаасан байна.

“МАЛЧНААР АЖИЛЛАЖ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ХУГАЦААГ ТОДОРХОЙЛОХ ЗӨВЛӨЛ”

Тайлант хугацаанд 10 сумын “Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл” 21 удаа хуралдаж 24 иргэний асуудал хэлэлцэж 20 малчинд зөвлөлийн тогтоол гаргасан байна. Зөвлөлийн тогтоол гаргасан иргэдээс 12 нь малчин тэтгэвэр тогтоолгосон байна

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2022 онд ЭХМКомисс нь нийт 48 удаагийн хурлаар 2791 иргэний асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Үүнд шинээр 277, цуцалсан 127, буцаасан 235, сунгагдсан 2151 иргэнд үйлчилсэн. Нүүдлийн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд болон ар гэрийн асран хамгаалагч нарт мэргэжлийн эмч нар, халамжийн байцаагч, нийгмийн даатгалын чиглэлээр тус тус сургалтыг 4 удаа хийсэн. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар 4 удаагийн сургалт мэдээллийг зохион байгуулж ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоох сунгах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй хуулийн хүрээнд, үнэн зөв шийдвэрлэж байна.

ЭХМКомиссын мэргэжилтэн эмч нар өвчний мэргэжлийн дагуу болон бусад өвчнийг хувиарилан авч сумдын болон өрх аймгийн эмч нартай хамтран эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөөг гарган хөдөлмөрийн чадварыг сэргээн засах тусламж үйлчилгээний талаар байгууллагуудад заавар зөвлөгөө өгч ажиллаа. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад сэргээн засах тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх, талаар албан тоот болон зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүний дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгийн сэргээн засах эмчилгээний тасгийг 20 ортой болгож өргөжүүлэн ажиллаж

эхэллээ. Гэмтэл болон мэдрэлийн чиглэлийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг жилд сэргээн засах тасагт 1 удаа хэвтэн эмчлүүлэх мөн 2—3 удаа өдрийн болон амбулаторийн үйлчилгээг авч байх зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаж байна.

Дотоод хяналтыг эрчимжүүлэх зорилгоор дахин магадлагааг хугацаагүй сунгалттай иргэдэд нүүдлийн хурлаар 4 дахин магадлал хийж нийт 73 иргэнийг хамруулсан. Үзлэг шинжилгээнд хамрагдаагүй 37 иргэнийг ЭХМКомиссын хурлаар оруулж шинжилгээ оношилгооны асуудлыг давтан хийлгэж сунгалтыг баталгаажууллаа. Оношийн дүгнэлт хангалтгүй 235 / давхардсан тоогоор/ иргэнийг буцааж дахин нарийн шинжилгээ үзлэгт хамруулсаны үндэсэн дээрээс 13 иргэний сунгалтыг хийсэн. 135 иргэнийг 3-6 сарын хяналтанд буцаасан мөн 5 харъяаллын бус, 15 нь өвчний ангилал таарахгүй, 6 иргэний шинэилгээний хугацаа дууссан байсаныг дахин хийлгэсэн. Улаанбаатар хот руу шаардлагатай 15 иргэнийг явуулж мэдрэл булчингийн бичлэг, нойрны ЭЭГ-5, АССР-25, IMRAI- 35, Ye солиулах мэс засалд -10 өвчтөнийг явуулсан. 27 иргэнийг цуцлаж эмчийн хяналтанд эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.

Эмнэлэг хөдөлмөр магадлалын цахим мэдээллийн сангийн бүрдэлд хяналт шалгалт хийж халамжийн мэргэжилтэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэй хувийн хэргийг баазтай тулгалт хийж 18 хүний заалт өөрчилж, 10 хүнийг хугацаагүй заалтанд шилжүүлж, хаягийн бүртгэл өөрчлөгдсөн 5 хүнийг шилжүүлж мөн шинэчилсэн заалттай холбогдуулж 1876 иргэдийн заалтыг өөрчилсөн. 56 иргэнийг нарийн мэргэжлийн эмч нартай хамтран үзлэг шинжилгээнд хамруулж 36 иргэнийг дахин шинжилгээнд хамруулж оношийн үндэслэлийг баталгаажуулж ажилласан.

2022 онд ЭХМК-ын гишүүн, нарийн мэргэжлийн эмч нартай хамтран эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан хөдөлмөрийн чадвараа алдсан 18 иргэнийг нөхөн сэргээсэн ба Хөдөлмөрийн чадвар алдалтын дундаж хувь 3,38 байна.

СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын чанар хүртээмж, хамралтыг сайжруулах зорилгоор ажил олгогч, даатгуулагч болон ажилтнуудыг мэргэшүүлэх, сургаж дадлагажуулахад анхаарч ажиллаа. Тухайлбал:

➤ Мэргэшүүлэх сургалтыг дотооддоо Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хэлтэс, орон нутгийн байгууллагаас зохион байгуулсан албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх **34** удаагийн цахим болон танхимын сургалтанд давхардсан тоогоор **468** албан хаагчдыг хамруулсан.



➤ Ажил олгогч даатгуулагчдад чигэлсэн сургалтыг оны эхнээс төлөвлөгөө гарган хэлтсийн даргаар батлуулан ажилласнаар нийтдээ **488** аж ахуйн нэгж байгууллага, **81** баг, **21** ЕБС-ийн ахлах ангийн сургачдад, **324** сургалт зохион байгуулж **18045** даатгуулагч хамруулсан.



- Хэнтий мэдээ сонины фэйж хуудас, сайтаар, www.ndaatgal.khe.gov.mn вэб сайт, www.facebook.com/NDKHenti фэйсбүүкээр, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс” фэйж хуудсаар **87** мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГ-аас бэлтгэсэн **55** төрлийн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд хүргэсэн ба давхардсан тоогоор **250** мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна.
- Нийт албан хаагчид НДЕГ-ын @sigomongolia фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээлэл авах, мэдээллийг

цааш түгээх ажлыг мэдээлэл технологийн мэргэжилтэн хариуцан ажилласнаар нийт **33** албан хаагч НДЕГ-ын фэйсбүүк хуудсыг дагаж, мэдээллийг цааш түгээн ажилласан.



- Явуулын үйлчилгээ **59** цэгт үзүүлж **1897** иргэд хамрагдсанаас тэтгэврийн нас дөхсөн **1130** даатгуулагчдад зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан:



- “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг **2** удаа ЭВТ худалдааны төвд болон сумдад нэг өдөр зохион байгуулж **431** иргэд, даатгуулагч хамруулсан.



- Даатгуулагчийн нэрэмжит” волейболын тэмцээн зохион байгуулж 24 багийн 200 тамирчид оролцлоо.

Мөн нийгмийн даатгалын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй ил тод байлгах талаар анхаарч ажилласан бөгөөд нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлий мэдээг шилэн дансанд сар бүр хугацаанд нь байршуулж, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг үйлчигээний зааланд байрших мэдээллийн самбарт тухай бүр байршуулан орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН БУЮУ ОНЦЛОХ АЖЛУУД



Аймагтаа 2021 онд төрийн байгууллагуудаас анхны ISO 9001:2015 стандартад нийцсэн Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж баталгаажуулалтын гэрчилгээг 3 жилийн хугацаатай авсан.

ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо- Шаардлага олон улсын стандартын хэрэгжилтэнд **Магадлах аудит-1**-ийг 2022 оны 5 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд амжилттай хамгаалж **МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ГАРЧИЛГЭЭГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХАДГАЛАХААР** боллоо.

ЧМТ-ны **ISO 9001:2015** стандартыг нийт **33** шаардлагаар үнэлэсэн ба давуу тал – **7**, сайжруулах боломж – **8**, анхаарах хэсэг **-0**, жижиг үл тохирол **-0**, том үл тохирол **-0** гэсэн үр дүнтэй хамгаалсан.



НДЕГазрын даргын 01 тоот Албан даалгаврын хүрээнд:

“Ёс зүй сахилга хариуцлагыг дээшлүүлэх” албан даалгаврын дагуу албан бичгээр ирүүлсэн зааврын дагуу доорх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

- Нийт албан хаагчдыг төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх **6** удаагийн сургалтанд, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх **7** удаагийн сургалтанд цахим болон танхимаар хамруулсан.
- Ёс зүйн зөвлөл 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулж, албан хаагчдыг Ёс зүйн дүрэмтэй танилцсан тухай баталгааг нийт албан хаагчдаар гаргуулж ажилд шинээр орж байгаа 4 албан хаагчдад ёс зүйн дүрэм танилцуулах ажлыг зохион байгуулсан.
- Хэлтэс болон сумдын байцаагчдын ажлын байранд Санал хүсэлт хүлээн авах утасны дугаарыг иргэд, даатгуулагчдын нүдэнд ил тусахаар 20 цэгт байршуулсан ба Угтах үйлчилгээний ажилтанг орон тоогоор ажиллуулж байна.
- Төрийн үйлчилгээний албан хаагчийн харилцаа хандлага, үйлчилгээний чанарыг үнэлэх төхөөрөмж, үйлчлүүлж буй иргэдийн бичлэг хийх ширээний камер, бичлэгийн төхөөрөмжийг тогтмол ажиллуулж үйлчилгээ авсан иргэд даатгуулагчаар үнэлгээ даруулан ажиллаж байна.

Оны эхнээс: **2185** иргэд, даатгуулагч үйлчлүүлсний:

- 87,6 хувь буюу 1914 маш сайн,
- 12 хувь буюу 262 сайн,
- 0.3 хувь буюу 7 дунд,
- 0.09 буюу 2 муу гэж үнэлсэн байна.


Үнэлгээний төхөөрөмж ажиллуулж эхэлсэнээр даатгуулагч, байцаагчдын хооронд ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй болно.

Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх

GREEN ERP санхүүгийн програмаар үйл ажиллагааны 2021 оны санхүүгийн 4-р улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг тайлганасан бөгөөд 2022 оны 1-3 дугаар улирлын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийн тайлан, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж байна. ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ний төслийн багийн хэрэгжүүлэх Green finance санхүүгийн программын онлайн сургалтанд нягтлан бодогч, нярав, хүний нөөцийн ажилчид тухай бүр хамрагдаж санхүүгийн програм дээр ажиллаж сарын мэдээ, тайланг гарган ажилласан.

“80 жил – 8 бүтээл” аяны хүрээнд:

- ✚ Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх эрх зүйн акт, ажлын байрны стандарт, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журмыг байцаагч ажилчдад танилцуулж дотоод үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, байгууллагын гаднах өнгө үзэмжийг өөрсдийн нөөц боломжиндоо тулгуурлан засаж сайжрууллаа.



- ✚ Ажлын цаг ашиглалт, бүртгэлийг сайжруулах чиглэлээр 2022 оны 10 дүгээр сараас 01-ний өдрөөс эхлэн <https://erp.e-mongolia.mn/> нэгдсэн системээр хэлтсийн байцаагч ажилчдын ирцийг бүртгэж хэвшээд байна. Сумдын байцаагчдыг сумын Засаг даргын тамгын газрын харъяанд мөн <https://erp.e-mongolia.mn/> нэгдсэн системд бүртгэж байна. Хүний нөөцийн программтай цагийн бүртгэлийг холбох бэлтгэл ажлыг хангаж цаг бүртгэлийн төхөөрөмжийг 11 дүгээр сарын 01-нээс эхлэн ажиллуулж цаг бүртгэлд хяналт тавин ажиллаж байна.



✚ “Хөдөлгөөн-Эрүүл мэнд”, “Эрүүл орчин-Эрүүл амьдрал”, “Та бол - бидний бахархал”, “Хайр - бидний гэр бүл” гэсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



✚ “Сэтгэлийн бэлэг”, “Дусал цус-Дүүрэн амьдрал” аяныг зохион байгуулж бусад төрийн байгууллагуудыг уриаллаа.



✚ “Байгаль орчноо хайрлая” аяны хүрээнд албан хаагчдын хүүхдүүдийн дунд “Эх дэлхийгээ хайрлая” сэдэвт гар зураг болон зай цуглуулах хайрцаг бүтээх уралдаан явуулж Иргэд, даатгуулагчдыг ирж үйлчлүүлэхдээ зай цуглуулах хайрцаганд хэргэлсэн зайгаа авчирч хийн эх дэлхийгээ хамгаалахыг уриалан ажиллаж байна.



Хэрлэн голын дагуух газрын хог хаягдал болон байгууллагынхаа орчин тойрны хог хаягдалыг цэвэрлэж байгууллагтаа хог ангилан хийх хогийн сав байрлуулав.



“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж нийт **138** мод тарьсан.

Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойд зориулан аймгийн нийтийн эзэмшлийн талбай болон байгууллагынхаа гадна талбайд нийтдээ 80 мод тарьж, арчилж усалж ургуулж байна. Нийтийн эзэмшлийн талбайд 10 ширхэг шинэс мод, байгууллагынхаа гадна 10 ширхэг голт бор, 60 ширхэг шархуйс тарьсан. Намар 2022 оны 10 дугаар сарын 13-нд аймгийн 100 жилийн ойг угтан байгуулж байгаа Цэцэрлэгт хүрээлэнд нийгмийн даатгалын нэрэмжит төгөл байгуулж 35 ширхэг мод, аймгийн хойно байрлах үерийн далангийн дагуу 13-14 дэх баганы хооронд хүн бүр нэг мод буюу нийт 23 мод суулгасан.





Эцэг эхийн зөвлөлийг шинэчилэн байгууллаа.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж” –ийн дагуу Эцэг эхийн зөвлөлийг шинэчилэн байгуулж 2022 онд хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж үйл ажиллагаа явуулж байна.

Ажлын төлөвлөгөөнд заагдсаны дагуу амралтын өрөөг “**Хүүхдийн өрөө**” болгон тохижуулж, албан хаагчдын хүүхдийн судалгааг шинэчилэн гаргаж, гэр бүлийн чиглэлээр “**Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргад суралцах**” сургалтанд хамруулсан.

“**Хайр - бидний гэр бүл**” сэдэвтэй үйл ажиллагааг зохион байгуулж ажлын нөрхцөл байдлаас болоод өдөр бүр мөн удаан хугацаагаар гэр бүлдээ ихэнх цаг заваа зориулж чаддаггүй улмаас хүүхдүүдэд хайр халамж, дутагдах ханьтайгаа зөвлөлдөх цаг хомс учраас гэр дотор үл ойлголцол гарах асуудал байдаг учраас гэр бүлдээ өөрсдийн ажлаа сурталчлах, хамт олноо танилцуулах, гэр бүлийн таатай уур амьсгалыг бүрдүүлж хүүхдүүдтэйгээ нэгэн өдрийг өнгөрүүлснээр бидний сэтгэл ханамж дээшилж ажилах эрч хүч нэмэгдэнэ гэж үзэж ажлын байр хамт олноо танилцуулж, хүүхэд хөгжлийн төвд хүүхэлдэйн кино үзүүлж, хүүхдүүдийн дунд зургийн болон зай цуглуулах хайрцагны уралдаан зарлаж, зурсан зургуудаар нь үзэсгэлэн гаргаж, аав ээжтэйгээ хамтдаа нэг өдрийг өнгөрүүлж хүүхдүүдтэйгээ хүүхэлдэйн кино үзэж хүүхдүүддээ өөрсдийн гараар хийсэн амттангаар дайллаа.





ТАЙЛАН БИЧСЭН :
ХЭЛТСИЙН ДАРГИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Н. НЯМХАТАН/